

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

АУДИТЫН КОД: ӨМА-2022/167/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Өмнөговь аймаг
Даланзадгад сум

2022 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр

Утас: 70533552 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Аудитор Т.Хишигбат

Утас: 70533552 Цахим хаяг: Khishigbatt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Нэг. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг баталгаажуулах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжих замаар мэргэжлийн удирдлагаар хангагч хүмүүнд ээлтэй, малчинд ойрхон байгууллага болох эрхэм зорилго тавин ажиллаж байна.

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/
Санхүүгийн байдлын тайлан		
	Үзүүлэлт	2021.12.31
	Эргэлтийн хөрөнгийн дүн	379.2
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,360.4
	Нийт хөрөнгийн дүн	2,739.6
	Нийт өр төлбөрийн дүн	
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,739.6
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,617.5
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,039.2
	Үйл ажиллагааны зардлын дүн	2,260.7
	Үйл ажиллагааны үр дүн	-221.6
	Үйл ажиллагааны бус үр дүн	
	Үйл ажиллагааны нийт үр дүн	-221.6
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,961.2
	Тайлант оны үр дүн	-221.6
	Эцсийн үлдэгдэл	2,739.6
Мөнгөн гүйлгээний тайлан		
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,218.0
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,175.4
	Үйл ажиллагааны ЦМГ	42.6
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-42.6
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	603.0
	Урсгал зардал	603.0
	Хөрөнгийн зардал	
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	603.0
	Улсын төсвөөс санхүүжих	593.5
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	9.5

Гурав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	8	11,780.5	4	1,483.4			1	737.1	3	9,560.0

5.2 Аудитын илрүүлэлт: /Илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга, түүнийг шийдвэрлэсэн байдал /хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал, залруулсан алдаа, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж//

Аудитаар нийт 11,780.5 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, 1,483.4 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, хууль тогтоомж хэрэгжүүлж ажиллах 737.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 9,560.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэртэй тулган баталгаажуулахад 896,300 төгрөг, санхүү байдлын тайлангийн өглөг дансыг тооцоо нийлсэн акттай тулган баталгаажуулахад 28,506.66 төгрөг, орлого үр дүнгийн тайлангийн цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг цалингийн өглөгтэй тулган баталгаажуулахад 113,395.86 төгрөг, мөнгөн гүйлгээний тайлантай тулган баталгаажуулахад 445,199.84 төгрөгийн зөрүүг залруулав.

Албан шаардлага:

Төсвийн хөрөнгийг зарцуулахдаа тээвэр шатахууны зардлаас 737,090 төгрөг зориулалт бусаар зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Зөвлөмж:

Шилэн дансны мэдээлэлд 150 мэдээлэл оруулахаас 6 мэдээллийг хоцруулсан байна. Тус байгууллагын үндсэн хөрөнгийн тайланд үлдэх өртөггүй 4 ширхэг бүртгэлтэй байна. Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 3,360,000 төгрөгийг сургалтын зардал зарцуулсан, 6,200,000 төгрөгийн ажлын дүрэмт хувцас, цамц худалдан авсан алдаа, зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

Зургаа. Аудитын санал дүгнэлт /баталгаажсан хувийг оруулах/



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

46083, Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон 304 тоот
Утас: (976) 7053 3539, Вэб сайт: www.audit.mn
И-мэйл: umnugovi@audit.gov.mn

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАЛ
ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
П.ОДБАЯР ТАНАА

2022. 02. 21 № 59
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өмнөговь аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЦЭРЭНБАЯР

D:\2021 Он\Бичиг хэрэг\Явсан Бичиг\2022-02-21 №59\с

010720000